

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Огноо: 2020-10-06

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН УС
ЦЭВЭРШҮҮЛЭХ ЗӨӨЛРҮҮЛЭХ ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛАХ АЖЛЫН
БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: *Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ус
цэвэршүүлэх зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах
ажил*

Гэрээний дугаар: *ОНТХО-ХА-04/2020*

**Даланжаргалан сум
2020 он**

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020-10-06

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргын тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ус цэвэршүүлэх зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах ажлын цахим тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50000** төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичиг худалдан авсан төлбөрийн баримтийг Орон нутгийн өмчийн газар ирүүлснээр энэхүү тендерт оролцох эрх үүсэх болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн материалыг **2020 оны 10-р сарын 13**-ний өдрийн 09 цаг 00 минутаас өмнө www.tender.gov.mn цахим хуудсаар ирүүлнэ үү.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 10-р сарын 13**-ний өдрийн 09 цаг 30 минутад нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорноговь аймаг Даланжаргалан сум 4-р баг Засаг даргын тамгын газар
Утас:99075643,
99738275

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Компанийн танилцуулга
 - (в) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (г) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан сүүлийн 1 жил, туршлагын мэдээлэл сүүлийн 1 жил, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар хүлээлгэн өгсөн актын хамт сүүлийн 1 жил/ болон бусад баримт бичиг;
 - Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар /Гадаад худалдаа/
 - Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл
 - Харилцагч банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх
 - Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх
 - Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх
 - Шүүүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх
 - Бараа, бүтээгдхүүний танилцуулга болон фото зураг,
техникийн тодохойлолтын хамт
/Тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш он сар өдрөөр ирүүлсэн байх/
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [I] жилийн санхүүгийн тайлан: 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт / Сүүлийн [I] жилийн туршлагын мэдээлэл: /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, ажил хүлээлцсэн актын хамт/;</p> <p>Бусад нэмэлт шаардлага; <i>/Тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш он сар өдрөөр ирүүлсэн байх/</i></p> <ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар /Гадаад худалдаа/ - Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл - Харилцагч банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Бараа, бүтээгдхүүний танилцуулга болон фото зураг, техникийн тодохойлолтын хамт
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: 2020 оны 10 сарын 13 өдөр 09 цаг 00 минут Тендер хүлээн авах этгээд: tender.gov.mn Байгууллагын хаяг: <i>Даланжаргалан сум</i> Давхар болон өрөөний дугаар: Аймаг, хот: <i>Дорноговь аймаг Даланжаргалан сум</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байшин, гудамжны нэр: Давхар болон өрөөний дугаар: 1 давхар Аймаг, хот: <i>Дорноговь аймаг Даланжаргалан сум</i>. Улс: <i>Монгол Улс</i>. Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: <i>2020 оны 10 дугаар сарын 13-ний өдөр</i>. Цаг: <i>09 цаг 30 минут</i>.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Дорноговь аймгийн ДаланДаланДаланДаланжаргалан сумын ус цэвэршүүлэх зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах ажлаас бүрдэнэ.</i></p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

СУМЫН ТӨВИЙН ХУДАГТ ТАВИХ УС ЦЭВЭРШҮҮЛЭХ, ЗӨӨЛРҮҮЛЭХ ТӨХӨӨРӨМЖ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- ☞ Гүний худгийн хатуулаг ихтэй усыг зөөлрүүлж, төмөргүйжүүлж, бохирдолыг шүүж цэвэршүүлэн хүний унданд хэрэглэх стандартын шаардлага бүрэн хангасан усыг боловсруулж гаргана.
- ☞ Хөдөөгийн сумын нөхцөл байдалд тохирсон, тухайн худгийн усны хими болон бактерийн шинжилгээнд үндэслэгдсэн, сумын төвийн ус хэрэглэгдийн судалгааг авч хүчин чадал, загварыг сонгосон төхөөрөмж тавих.
- ☞ Үндэсний технологиор сэргээлт хийж, удаан хугацаатай ашиглах бол давуу талтай.
- ☞ Хийц үзэмж сайн, задалж угсрахад хялбар байх
- ☞ Зэв тунадас, илүүдэл хлор, магни, усны хатуулагыг эх орны олодоц сайтай хадан цагаан, цеолит, кварцын элс, стандарт хайрган шүүлтүүрээр шүүж цэвэрлэх бол сайн.
- ☞ Ион солилцогч бодис, шүүр эд ангийг задалж солих боломжтой байх
- ☞ Шүүгдэж гарсан бохир усыг худагт буцааж оруулахгүйгээр гадагшлуулах

ТЕХНИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Ус цэвэршүүлэх хүчин чадал /м³/цаг/ 2,0 – 4,0

Орох даралт /м.у.б/ 20 – 40

Гарах даралт /м.у.б/ 15 – 40

Шүүгүүр материалын дундаж /орц, кг/ - 100

Дундаж цахилгаан зарцуулалт /квт/м³/ - 0,75

Чанарыг сайжруулах технологийн шаардах үзүүлэлт

Өнгө, градусаас бага	15
Булингар, мг/л-с бага	1
Амт, оноо	1
Үнэр, оноо	1
pH	6.5-8
Нефть бүтээгдэхүүн, мг/л-с бага	0.1
Төмөр, мг/л-с бага	0.1
Чөлөөт хлор, мг/л-с бага	0.1
Бохирдлын үзүүлэлт, мг/л	0
Хатуулаг, мг.экв/л	2.5-5

Худгийн усны шинжилгээний дүнг хавсаргав

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ГАЗРЫН СОРИЛТЫН
ЛАБОРАТОРИ**

Дорноговь аймаг, Сайшианд сум, 2-р баг.
Утас: 70522352, Вэб хаяг: Dornogovi.inspection.gov.mn



**ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
CERTIFICATE OF ANALYSIS**

Бүртгэлийн дугаар /Registration number/: 20-148

Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр : Дорноговь аймаг, Даланжаргалан сум, ЗДТГ

(The name of customer's request for analysis)

Байцаагчийн нэр /The name of inspector/: Л.Бямбатуяа

Дэд лабораторийн нэр /Name of the sub laboratory/: Эрүүл ахуйн нян судлалын хяналтын лаборатори; Эрүүл ахуйн хими, хор судлалын хяналтын лаборатори

Дэжгийн тодорхойлолт /Sample description/					
Дэжгийн дугаар /Sample number/	Дэжгийн нэр /Name of sample/	Цувралын дугаар /Batch number/	Үйлдвэрлэсэн улс /The country of original manufacturer/	Хүчинтэй хугацаа /Date of expiry/	Дэжгийн тоо хэмжээ /Quantity of the sample/
620	Томорзамын худгийн ус № 01		Монгол Улс	Тодорхойгүй	1250 мл
621	ухаалаг худаг № 03		Монгол Улс	Тодорхойгүй	1250 мл
622	гүний худаг № 04,07 / эмнэлэг шүүлтүүртэй/		Монгол Улс	Тодорхойгүй	1250 мл
623	гүний худаг №05 / эмнэлэг шүүлтүүргүй/		Монгол Улс	Тодорхойгүй	1250 мл

Хүлээн авсан огноо /Date of receipt/	Шинжилгээ дууссан огноо /Date of test completion/	Хэвлэсэн огноо /Date of issue of the report/
2020 он 04 сар 29 өдөр	2020 он 05 сар 02 өдөр	2020 он 05 сар 04 өдөр

Дэжгийн дугаар /Sample number/	Шинжилгээний аргын стандарт /Method of analysis/	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж /Test parameter, unit/	Шаардлага /Test specification, unit/	Шинжилгээний дүн /Test result/
620	MNS 6546:2015	<i>Pseudomonas aeruginosa</i>	Илрэхгүй	Илрээгүй
	MNS ISO 6222:1998	ББЕТ	100	535
	MNS ISO 19250:2017	<i>Salmonella spp</i>	Илрэхгүй	Илрээгүй
	MNS ISO 9308-1:1998	Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян /ялтас шүүлтүүр/	Илрэхгүй	Илрээгүй
	MNS ISO 21567:2011	<i>Shigella spp</i>	Илрэхгүй	Илрээгүй
	ЭАХХСЛ.5.4.45	Аммони	1.5мг/л	0.295мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Кальци ион	100.0мг/л	110.2мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Магни ион	30.0мг/л	27.9мг/л
	MNS 4430:2005	Нийт төмөр	0.3мг/л	0.41мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Нитрат ион	50.0мг/л	12.4мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Нитрит ион	1.0мг/л	0.065мг/л
	MNS ISO 10523:2001	pH	6.5-8.5pH	7.22pH
	ЭАХХСЛ.5.4.45	Сульфат ион	500.0мг/л	866.8мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Фтор ион	0.7-1.5мг/л	2.5мг/л- ээс их
	ЭАХХСЛ.5.4.60	Хатуулаг	7.0мг-экв/л	7.0мг-экв/л
	ЭАХХСЛ.5.4.45	Хлор ион	350.0мг/л	928.7мг/л
MNS ISO 7888:1999	Цахилгаан дамжуулах чанар	1.0мСм/см	3.02мСм/см	
621	MNS 6546:2015	<i>Pseudomonas aeruginosa</i>	Илрэхгүй	Илрээгүй
	MNS ISO 6222:1998	ББЕТ	100	122
	MNS ISO 19250:2017	<i>Salmonella spp</i>	Илрэхгүй	Илрээгүй
	MNS ISO 9308-1:1998	Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян /ялтас шүүлтүүр/	Илрэхгүй	Илрээгүй
	MNS ISO 21567:2011	<i>Shigella spp</i>	Илрэхгүй	Илрээгүй
	ЭАХХСЛ.5.4.45	Аммони	1.5мг/л	0.29мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Кальци ион	100.0мг/л	112.2мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Магни ион	30.0мг/л	25.5мг/л
	MNS 4430:2005	Нийт төмөр	0.3мг/л	0.29мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Нитрат ион	50.0мг/л	12.3мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Нитрит ион	1.0мг/л	0.0225мг/л
	MNS ISO 10523:2001	pH	6.5-8.5pH	7.14pH
	ЭАХХСЛ.5.4.45	Сульфат ион	500.0мг/л	1035.1мг/л

GASI-LIMS

Дээжийн дугаар	Шинжилгээний аргын стандарт	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Шаардлага	Шинжилгээний дүн
622	ЭАХХСЛ.5.4.45	Фтор ион	0.7-1.5мг/л	2.5мг/л-ээс их
	ЭАХХСЛ.5.4.60	Хатуулаг	7.0мг-эсв/л	9.0мг-эсв/л
	ЭАХХСЛ.5.4.45	Хлор ион	350.0мг/л	978.3мг/л
	MNS ISO 7888:1999	Цахилгаан дамжуулах чанар	1.0мСм/см	4.83мСм/см
	MNS 6546:2015	<i>Pseudomonas aeruginosa</i>	Илрэхгүй	Илрэхгүй
	MNS ISO 6222:1998	ББЕТ	100	137
	MNS ISO 19250:2017	<i>Salmonella spp</i>	Илрэхгүй	Илрэхгүй
	MNS ISO 9308-1:1998	Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян /ялтас шүүдлүүр/	Илрэхгүй	Илрэхгүй
	MNS ISO 21567:2011	<i>Shigella spp</i>	Илрэхгүй	Илрэхгүй
	ЭАХХСЛ.5.4.45	Аммоний	1.5мг/л	0.247мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Кальций ион	100.0мг/л	33.1мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Магний ион	30.0мг/л	25.5мг/л
	MNS 4430:2005	Нийт төмөр	0.3мг/л	0.305мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Нитрат ион	50.0мг/л	12.9мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Нитрит ион	1.0мг/л	0.007мг/л
	MNS ISO 10523:2001	pH	6.5-8.5pH	7.30pH
	ЭАХХСЛ.5.4.45	Сульфат ион	500.0мг/л	340.0мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Фтор ион	0.7-1.5мг/л	2.5мг/л-ээс их
	ЭАХХСЛ.5.4.45	Хлор ион	7.0мг-эсв/л	4.1мг-эсв/л
	ЭАХХСЛ.5.4.45	Хлор ион	350.0мг/л	120.5мг/л
623	MNS ISO 7888:1999	Цахилгаан дамжуулах чанар	1.0мСм/см	1.280мСм/см
	MNS 6546:2015	<i>Pseudomonas aeruginosa</i>	Илрэхгүй	Илрэхгүй
	MNS ISO 6222:1998	ББЕТ	100	399
	MNS ISO 19250:2017	<i>Salmonella spp</i>	Илрэхгүй	Илрэхгүй
	MNS ISO 9308-1:1998	Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян /ялтас шүүдлүүр/	Илрэхгүй	Илрэхгүй
	MNS ISO 21567:2011	<i>Shigella spp</i>	Илрэхгүй	Илрэхгүй
	ЭАХХСЛ.5.4.45	Аммоний	1.5мг/л	0.29мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Кальций ион	100.0мг/л	35.1мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Магний ион	30.0мг/л	24.3мг/л
	MNS 4430:2005	Нийт төмөр	0.3мг/л	0.24мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Нитрат ион	50.0мг/л	13.2мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Нитрит ион	1.0мг/л	0.008мг/л
	MNS ISO 10523:2001	pH	6.5-8.5pH	7.36pH
	ЭАХХСЛ.5.4.45	Сульфат ион	500.0мг/л	332.0мг/л
	ЭАХХСЛ.5.4.45	Фтор ион	0.7-1.5мг/л	2.5мг/л-ээс их
	ЭАХХСЛ.5.4.60	Хатуулаг	7.0мг-эсв/л	4.3мг-эсв/л
	ЭАХХСЛ.5.4.45	Хлор ион	350.0мг/л	127.6мг/л
	MNS ISO 7888:1999	Цахилгаан дамжуулах чанар	1.0мСм/см	1.294мСм/см

Санал тайлбар:

Opinions and interpretation

БАТАЛСАН: ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ:

Approved by



Г. МӨНХТУЯА

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн дээжинд хамаарна. Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодор хойло лт	ширхэг	Хэм жих нэг ж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүл Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	нийлүүл эгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
<i>Дорноговь аймгийн Даланжарга лан сумын ус цэвэршүүлэх зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах ажил</i>		<i>1</i>	<i>ш</i>	<i>Дорноговь Даланжаргалан 5-р баг</i>	<i>2020.10.23</i>	<i>2020.10.30</i>	

--	--	--	--	--	--	--	--

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [моо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ	
						болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГГИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерг оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч,			
	холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)- д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон барааг хүлээлгэх өгсөн акт, бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа /6/сар байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш /ГТН-д заасан тоо/ хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгү | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа |

**й-гээс гэрээг
цуцлах**

хохирлыг нийлүүлэгч барагдуулна.

**11. Маргааныг
шийдвэрлэх**

11.1. Талууд гэрээний үүргийн биелэлтэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹**
- Алданги оногдуулах хувь: Хоногийн 0.5
- Алдангийн нийт дүн: 10 %

¹ Ихэнх тохиолдолд нэг долоо хоног тоногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүнг эрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

_____ (Тамга, тэмдэг) _____

_____ (Тамга, тэмдэг) _____

_____ (Гарын үсэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

_____ (Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож

_____ оны ____ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ____ дугаар сарын ____ -наас _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.